



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

Д.ХЭТЭВЧ АШИГЛАХ ЗААВАР


D.ХЭТЭВЧ АШИГЛАХ ЗААВАР

Trade.mn системд бүртгэлээ бүрэн баталгаажуулснаар хэрэглэгчид хэтэвч үүснэ. Уг хэтэвчийг ашиглан криптовалютын болон төгрөгийн орлого, зарлага хүлээн авах боломжтой болно.


1. ОРЛОГО ХИЙХ ЗААВАР

1.1 ТӨГРӨГИЙН ОРЛОГО ХИЙХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.



▶ АЛХАМ 3. Орлого товчин дээр дарна.

trade

АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT шинэ

ХЭТЭВЧ

Ерөнхий

Түүх

Идэвхтэй

Захиалга

Арилжаа

Орлого

Зарлага

Ерөнхий

Хайлт

Ойролцоо үлдэгдэл

***** BTC

≈ *****MNT

Үндсэн хөрөнгийн мэдээлэл

Бага дүнтэйг нуух

Хослолууд	Захиалгад байгаа	Savings-д байгаа	Үлдэгдэл	Тусгаарласан
MNT Tether	0 0 ₮	0 0 ₮	929 929 ₮	0 0 ₮
TRD Digital Exchange Coin	0 0 ₮	0 0 ₮	1,000 260 ₮	0 0 ₮
ICTG ICTG Security Token	0 0 ₮	0 0 ₮	0 0 ₮	0 0 ₮

▶ АЛХАМ 4. Төгрөг /MNT/ сонголтыг сонгоно.

1 Койн сонгох

2 Хаяг

Орлогын сонголтоо хийнэ үү

Орлого/Зарлага түүх


Хайлт хийх...

#	Нэр
1	Төгрөг MNT
2	Digital Exchange Coin TRD
3	ICTG Security Token ICTG
4	Storepay Coin SPC
5	BIDCoin BID


QRay болон Банкны дансаар төгрөгийн орлого хийх боломжтой байдаг тул QRay болон Банкны данс сонголтоос хамаарч орлого хийх үйлдлүүд нь өөр байдаг.

Qpay:


► **АЛХАМ 5.** Qpay сонголтыг сонгосон бол орлого хийх мөнгөн дүнгээ бичээд **Qpay** орлого хийх гэсэн товчин дээр дарна.



► **АЛХАМ 6.** Та **1 дугаарт** Орлого хийх мөнгөн дүнг бичих эсвэл **2 дугаарт** орлого хийх мөнгөн дүнгээ сонгоно уу.




► **АЛХАМ 7.** Гарч ирсэн QR кодыг өөрийн бүртгэлтэй банкны интернэт банк дээрх QR уншигчаар уншуулж орлогын гүйлгээг хийнэ.




Банкны дансаар:


▶ АЛХАМ 8. Банкны данс гэсэн сонголтыг сонгоно.



▶ АЛХАМ 9. Өөрийн бүртгэлтэй дансны харилцах банкыг сонгоно.



▶ **АЛХАМ 10.** Дансны дугаар, Дансны нэр, Гүйлгээний утгыг хуулж авна.



▶ **АЛХАМ 11.** Өөрийн бүртгэлтэй банкны интернэт банкаар нэвтэрч гүйлгээ хийнэ.


Хэрэглэгч зааврын дагуу орлогын гүйлгээ шилжүүлснээр 3 минутын дотор хэтэвч автоматаар цэнэглэгдэх болно. Төгрөгийн орлого хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.



- » Гүйлгээний утга дээр бүртгэлтэй имэйл хаягаа бичиж шилжүүлнэ.
- » Гүйлгээний утга алдаатай шилжүүлсэн тохиолдолд гүйлгээг буцаана.
- » Банк хооронд шилжүүлэг хийсэн тохиолдолд банкны цагийн хуваариар хэтэвч цэнэглэгдэх тул банк хоорондын шилжүүлэг хийхдээ анхаарна уу.
- » Зөвхөн орлого хүлээн авах данс руу шилжүүлэг хийх бөгөөд хэрэв тэгээгүй тохиолдолд орлого автоматаар орохгүй болно.
- » Зөвхөн trade.mn-д бүртгүүлж, баталгаажуулсан банкны данснаасаа орлогыг шилжүүлэх шаардлагатай ба орлого 3 минутын дотор орно.
- » 23:30-00:30 цагийн хооронд банкны өндөрлөгөө хаалт таардаг тул тухайн хугацаанд орлого хийхгүй байхыг анхаарна уу.

1.2 КРИПТО ОРЛОГО ХИЙХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх

Та доорх URL-р эзб хөгчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦ УГ


Нууц үг мартсан?

I'm not a robot

reCAPTCHA
Privacy - Terms

Нэвтрэх

▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.




trade АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT **шинэ** ХЭТЭВЧ


Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

➤ **АЛХАМ 3.** Орлого товчин дээр дарна.




➤ **АЛХАМ 4.** Орлого хийх гэж буй койноо сонгоно.



➤ **АЛХАМ 5.**

1. **Сүлжээ сонгох** хэсэгт өөрийн орлого хийх гэж байгаа койны сүлжээг сонгоно.
2. Сүлжээг сонгосон бол таны койн орлогын хаяг гарч ирэх тул **хаягаа хуулж авна**.



▶ **АЛХАМ 6.** Шилжүүлэгч талын Зарлага хүлээн авах хаяг хэсэгт манай дээрх өөрийн койн орлогын хаягийг хуулж тавиад сүлжээний сонголтоо зөв сонгон зарлага гаргана.



Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу орлогын гүйлгээ шилжүүлснээр манай дээр заасан сүлжээний баталгаажуулалтын тоонд хүрсэн тохиолдолд хэтэвч автоматаар цэнэглэгдэх болно. Крипто орлого хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- » Буруу сүлжээгээр эсвэл хаягаа буруу шилжүүлсэн гүйлгээг TRADE.MN хариуцахгүй.
- » Contract орлогын шилжүүлэг дэмжихгүй.
- » Манай дээр бүртгэлгүй койны шилжүүлэг хүлээн авахгүй.
- » Сүлжээний сонголтоо зөв хийсэн эсэхээ шалгана уу.

2. ЗАРЛАГА ХИЙХ ЗААВАР

2.1 ТӨГРӨГИЙН ЗАРЛАГА ХИЙХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх


Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦУГ


[Нууц үг мартсан?](#)

I'm not a robot 



[Privacy - Terms](#)

Нэвтрэх


▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.



[АРИЛЖАА](#)
[ТУСЛАМЖ](#)
[SAVINGS](#)
[NFT](#)
[ШИНЭ](#)





ХЭТЭВЧ



Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.



▶ **АЛХАМ 3. Зарлага товчин дээр дарна.**

Ерөнхий

Ойролцоо үлдэгдэл
 ***** BTC
 ≈ *****MNT

Үндсэн хөрөнгийн мэдээлэл Бага дүнтэйг нуух

Хослолууд	Захиалгад байгаа	Savings-д байгаа	Үлдэгдэл	Тусгаарласан
MNT Төгрөг	0 0 ₮	0 0 ₮	929 929 ₮	0 0 ₮
TRD Digital Exchange Coin	0 0 ₮	0 0 ₮	1,000 260 ₮	0 0 ₮

Buttons: Орлого, **Зарлага**

▶ **АЛХАМ 4. Төгрөг /MNT/ сонголтыг сонгоно.**

Зарлагын сонголтоо хийнэ үү Орлого/Зарлага түүх

Хайлт хийх...

#	Нэр
1	Төгрөг MNT
2	Digital Exchange Coin TRD

Progress: 1 Койн сонгох, 2 Хэмжээ оруулах, 3 Шилжүүлгийн тухай, 4 Баталгаажуулалт

▶ **АЛХАМ 5.**

1. Дансаа сонгоно уу хэсэгт өөрийн бүртгэлтэй банкны дансыг сонгоно.
2. Зарлага хийх хэмжээ хэсэгт зарлага гаргах хүсэлтэй байгаа хэмжээгээ оруулна.
3. Зарлага гаргах товчин дээр дарна.

Зарлагын хэмжээ

Таны боломжит үлдэгдэл

ЗАРЛАГА ХИЙХ БАТАЛГААЖСАН ДАНС

1 ХААН БАНК

ЗАРЛАГА ХИЙХ ХЭМЖЭЭ

2 100,000 MAX

Зарлагын доод хэмжээ: 1,000 MNT
 Зарлагын дээд хэмжээ: 20,000,000 MNT

Шимтгэл 1% 1,000 ₮ Таны авах дүн 99,000 ₮

3 **Зарлага гаргах**

Progress: 1 Койн сонгох, 2 Хэмжээ оруулах, 3 Шилжүүлгийн тухай, 4 Баталгаажуулалт

▶ **АЛХАМ 6.** Таны зарлагын мэдээллийн хуудас гарч ирэх бөгөөд уг хэсэгтэй сайн танилцаж **За ойлголоо, Үргэлжлүүлье** товчин дээр дарна.

▶ **АЛХАМ 7.** Зарлага баталгаажуулалтын хэсэгт шилжинэ.

1. **Баталгаажуулах код** хэсэгт таны бүртгэлтэй утсанд ирсэн зарлага баталгаажуулах 6 оронтой кодыг хийнэ.
2. **2FA код** хэсэгт Google Authenticator апп дээрх 6 оронтой кодыг хийнэ.
3. **Баталгаажуулах** товчин дээр дарж зарлагыг баталгаажуулна.




Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу зарлагын баталгаажуулалт хийснээр зарлага дарааллын дагуу гарах болно. Төгрөгийн зарлага хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.


- » 2FA хамгаалалтыг идэвхжүүлсэн байх шаардлагатай.
- » Зарлага гаргах данс нь хэрэглэгчийн өөрийн нэр дээрх данс байх шаардлагатай.

2.2 КРИПТО ЗАРЛАГА ХИЙХ


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.




▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 3.** Зарлага товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 4.** Зарлага хийх койныг сонгоно.



▶ АЛХАМ 5.

1. **Сүлжээ сонгох** хэсэгт тухайн зарлага хийх гэж байгаа койны сүлжээг сонгоно.
2. **Зарлага хийх хаяг** хэсэгт Орлого хүлээн авах талын хаягийг хуулж тавина.
3. **Зарлага хийх хэмжээ** хэсэгт зарлага гаргах хүсэлтэй хэмжээгээ оруулна.
4. **Хүлээн авагчийн Овог, Нэр** хэсэгт хүлээн авагчийн овог нэрийг бичнэ.
5. **Хүлээн авагчийн хаягийн төрөл** хэсгээс Бирж хаяг, Хэтэвч хаяг гэсэн сонголтоос таарах сонголтыг сонгож Хэтэвч сонгох хэсгээс биржийн нэр эсвэл хэтэвчийг үнэн зөв сонгоно.
6. **Шилжүүлэг хийх хөрөнгийн эх үүсвэр** хэсгээс өөрийн эх үүсвэрийн аль тохирох үнэн зөв сонголтыг сонгоно.
7. **Зарлага гаргах** товчин дээр дарна.

- ✓ Койн сонгох
- 2 Хэмжээ оруулах
- 3 Шилжүүлгийн тухай
- 4 Баталгаажуулалт

←

Зарлагын сонголт

КОЙН Нийт үлдэгдэл: 5,123.14906086 TRD

⊕
TRD
▼

СҮЛЖЭЭ СОНГОХ

⊞
BINANCE SMART CHAIN (BEP20)
▼

■ Анхааруулга

○ [Зөвхөн BEP20 сүлжээний хаяг оруулна]

ЗАРЛАГА ХИЙХ ХАЯГ

Шинэ хаяг

Хадгалсан хаягууд

ЗАРЛАГА ХИЙХ ХАЯГ

0xD912d3F0233e29c5Bb699674862d8661fA9114a66

ЗАРЛАГА ХИЙХ ХЭМЖЭЭ Боломжит үлдэгдэл: ██████████

3
5,000
MAX

Зарлагын доод хэмжээ: 2,000 TRD

Зарлагын дээд хэмжээ: 250,000,000 TRD

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ОВОГ, НЭР

██████████

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ХАЯГИЙН ТӨРӨЛ

5
Trade
▼

ШИЛЖҮҮЛЭГ ХИЙХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

6
Хувьцаа, үнэт цаас, крип...
▼

⊞

Шийтгэл

500 TRD


⊞

Таны авах дүн


4,500 TRD

7
Зарлага гаргах

▶ **АЛХАМ 6.** Гарч ирэх анхааруулга хэсэгтэй танилцаж **Тийм, Зөвшөөрнө** товчин дээр дарна.




▶ **АЛХАМ 7.** Таны зарлагын мэдээллийн хуудас гарч ирэх бөгөөд уг хэсэгтэй сайн танилцаж **За ойлголоо, Үргэлжлүүлье** товчин дээр дарна.



Анхааруулга: Шилжүүлэг хийж буй койны зарлагын сүлжээ хүлээн авагч талын орлогын сүлжээтэй таарч буй эсэхийг сайн шалгана.

▶ **АЛХАМ 8.** Зарлага баталгаажуулалтын хэсэгт шилжинэ.

1. **Баталгаажуулах код** хэсэгт таны бүртгэлтэй утсанд ирсэн зарлага баталгаажуулах 6 оронтой кодыг хийнэ.
2. **2FA код** хэсэгт Google Authenticator апп дээрх 6 оронтой кодыг хийнэ.
3. **Баталгаажуулах** товчин дээр дарж зарлага гарна.
 - » Зарлага хийх хаяг нь хүлээн авагч талын хаягтай таарч буй эсэхийг сайтар нягтлаж зарлага баталгаажуулалтаа хийнэ үү.



Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу зарлагын баталгаажуулалт хийснээр зарлага дарааллын дагуу гарах болно.

Крипто зарлага хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- » Буруу сүлжээгээр эсвэл хаягаа буруу шилжүүлсэн гүйлгээг TRADE.MN хариуцахгүй.
- » Сүлжээний сонголтоо зөв хийсэн эсэхээ шалгана.
- » Хаягаа зөв хуулж тавьсан эсэхээ сайтар шалгана.
- » 2FA хамгаалалтыг идэвхжүүлсэн байх шаардлагатай.
- » Зарлага хийх хаягаа дахин нягталж харахыг зөвлөө.

3. ТАЙЛАН ҮЗЭХ ЗААВАР

Тайлан хэсгээс хэрэглэгч Орлого/Зарлага, Гүйлгээний түүх зэрэг түүхээ хугацаагаар шүүж хайж харах боломжтой бөгөөд файл хэлбэрээр татаж авах боломжтой байдаг.


3.1 ОРЛОГО/ЗАРЛАГЫН ТҮҮХ ХАРАХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.

▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **цаасны зурган** дээр дарна.

▶ АЛХАМ 3. Орлого/Зарлагын түүх шалгах:

1. **Валют сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа валютаа сонгоно.
2. **Сонгох** хэсэгт Орлого, Зарлагын төрлөө сонгоно.
3. **Хугацаа** хэсэгт хамрах хугацаагаа оруулна.
4. **Хайх** товчийг дарна.
5. Хэрэв файлаар авах хүсэлтэй бол та **Экспорт** товчин дээр дарж файлаар авах боломжтой.



3.2 ГҮЙЛГЭЭНИЙ ТҮҮХ ХАРАХ

1. **Валют сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа валютаа сонгоно.
2. **Хослол сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа хослолоо сонгоно.
3. **Төрөл сонгох** хэсэгт гүйлгээний төрлөө сонгоно.
4. **Хугацаа** хэсэгт хамрах хугацаагаа оруулна.
5. **Хайх** товчийг дарна.
6. Хэрэв файлаар авах хүсэлтэй бол та **Экспорт** товчин дээр дарж файлаар авах боломжтой.

